ХУРГАТАЙ ХАЙРХАН

Ярилцлагын булан

“Өсвөрийн түвшинд системтэйгээр ажиллаж чадвал манай улс олон жил жүдогийн дэлхийн хүчтэй гүрэн хэвээр байх боломжтой”

-Д.Нармандах

ХУРГАТАЙ ХАЙРХАН



Юуны өмнө Атланта-1996 олимпын хүрэл медальт, Монголын жүдогийн анхны Ази тивийн аварга, гавьяат тамирчин Д.Нармандах танд өөрийн нэрэмжит олон улсын тэмцээнээ тасралтгүй **29 дахь жилдээ** амжилттай зохион байгуулсанд баяр хүргэе.

Энэ тэмцээнийг уламжлал болгон жил бүр зохион байгуулах санаа хэрхэн төрсөн бэ

Монголын жүдогийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулахыг хүсдэг байсан. Олимп, Азийн аваргад барилдаж байсан туршлагаа өсвөр үеийнхэнтэй хуваалцаж, тэдэнд урам зориг өгөх зорилгоор энэхүү нэрэмжит тэмцээнийг бий болгосон. Жил бүр уламжлал болгон зохион байгуулснаар олон залуу тамирчин туршлага хуримтлуулж, бэлтгэл сургуулилтаа ахиулах боломжтой болно гэдэгт итгэдэг.

ХУРГАТАЙ ХАЙРХАН

Энэ удаагийн тэмцээн өсвөр үеийн тамирчдад зориулагдсанаараа онцлогтой. Өсвөрийн тамирчдын ур чадвар, сэтгэл зүй, тэмцээний туршлагад ямар нөлөө үзүүлнэ гэж та үзэж байна вэ?

Өсвөрийн тамирчдад тэмцээний уур амьсгалыг мэдрүүлэх нь хамгийн чухал. Дэлхийн жудо өндөр түвшинд хүрсэн энэ үед зөвхөн дасгал сургуулилт биш, бодит тэмцээнд хүч үзэх замаар хурцлагдах хэрэгтэй. Энэ тэмцээн тамирчдад анхны том сорилт болж, цаашдын замналд томоохон туршлага өгнө.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

Тэмцээний зорилго нь Монгол Улсын жүдогийн хөгжлийг дэмжихэд чиглэж буй. Монгол Улсад жүдо спортын ирээдүйг та хэрхэн харж байна вэ?



Манай жүдо олон жил дэлхийн тавцанд өндөр амжилт гаргасан. Ирээдүйд ч залгамж халаа болсон тамирчид маш их байна.

Өсвөрийн түвшинд системтэйгээр ажиллаж чадвал манай улс олон жил жүдогийн дэлхийн хүчтэй гүрэн хэвээр байх боломжтой.

ХУРГАТАЙ ХАЙРХАН

Ирээдүйд “Хургатай Хайрхан” ХХК-ийн дэмжлэгтэйгээр энэ тэмцээнийг улам өргөжүүлж, спортын хөгжилд урт хугацааны ямар хамтын ажиллагаа өрнүүлэхээр төсөөлж байна вэ?

Энэ тэмцээнээр шалгарсан тамирчдыг улсын чанартай уралдаанд оролцуулах, холбооны анхааралд оруулах боломж нээгдэж байгаа. Өөрөөр хэлбэл, олон улсын түвшинд бэлтгэгдэх эхний алхам болж байна. Иймд “Хургатай Хайрхан” ХХК-тай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлж, залуу тамирчдын сургалт, бэлтгэлийн тал дээр ч хамтарч ажиллана гэж найдаж байна.

